



2018. 06. 27

142

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1.2, 11.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Авто замын норм, нормативын сангийн ажиллах журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, сангийн Удирдах болон Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай

2. Авто замын норм, нормативын баримт бичгийг боловсруулах, сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах, сан бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг журмын хүрээнд зохион байгуулахыг "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ /Р.Буд/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Э.Энхбат/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/-т тус тус үүрэг болгосугай.


САЙД

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн
142 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АВТО ЗАМЫН НОРМ, НОРМАТИВЫН САНГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл



1.1. Авто замын норм, нормативын сан /цаашид "Сан" гэх/-ийн ажиллах журмын зорилго нь Авто замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.4, 10.1.6, 11 дүгээр зүйлийн 11.1.2, 11.1.4, 11.1.6, 11.1.10 дахь заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 90 дүгээр тушаалыг тус тус хэрэгжүүлж, Монгол Улсын авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийн судалгаа хийх, боловсруулах, батлуулах, хэвлэн олшруулах, сурталчлахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, түүнийг зориулалтын дагуу зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Сангийн Удирдах зөвлөлийн баталсан төлөвлөгөөний дагуу авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийг боловсруулах ажлыг Авто замын судалгаа, шинжилгээ, хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага ("Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ буюу цаашид "Төв" гэх) хариуцан зохион байгуулна.

1.3. Сангийн хөрөнгөөр авто зам, замын байгууламжийн норм, норматив техникийн баримт бичгийг боловсруулахад салбарын эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, авто замын барилга, засвар, техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажил, зөвлөх үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээд, иргэдийг оролцуулах зарчмыг баримтална.

1.4. Сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, сурталчлах ажлыг Төв холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна. Сан нь Төвийн тэмдэг, хэвлэмэл хуудсыг хэрэглэнэ.

1.5. Сангийн орлогыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн сан дахь бүртгэлийн дансанд төвлөрүүлж, энэ журмын 3.2-т заасан хугацаанд Санд төвлөрүүлнэ.

1.6. Сангийн хөрөнгийн орлого, зарлагын баримтад Төвийн захирал нэгдүгээр, ерөнхий нягтлан бодогч хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж, баталгаажуулна.

1.7. Сангийн хөрөнгийн зарцуулалттай холбогдсон анхан шатны баримт бичиг, нягтлан бодох бүртгэл хөтлөх үйл ажиллагаа нь Төвийн нягтлан бодох бүртгэл хөтлөх үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг байна.

Хоёр. Сангийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийг боловсруулах, хянуулах, батлуулах, хэвлэн олшруулах, сурталчлах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах сангийн үйл ажиллагааг удирдах үүрэг бүхий Сангийн удирдах зөвлөл /цаашид "Удирдах зөвлөл" гэх/, сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг хянах Хяналтын зөвлөл /цаашид "Хяналтын зөвлөл" гэх/ тус тус ажиллана.

2.2. Удирдах зөвлөл нь 9, Хяналтын зөвлөл нь 5-аас доошгүй гишүүнтэй байна. Гишүүдийг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Зөвлөлийн бүрэлдэхүүнд авто

замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төв, Нийслэлийн авто замын хөгжлийн газар, авто замын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулна. Удирдах болон Хяналтын зөвлөлийн гишүүн нь "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.3 дахь заалтын шаардлагыг хангасан байна.

2.3. Удирдах зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.3.1. Сангийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг хянан хэлэлцэж батлах —

2.3.2. Тухайн жилд боловсруулах авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичиг, судалгааны ажлын жагсаалт, нэр төрөл, тэдгээрийг боловсруулах, хэвлүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг батлах;

2.3.3. Авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийн боловсруулалтын ажлын явц, тайланг хэлэлцэж, шаардлагатай арга хэмжээг авах;

2.3.4. Сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хяналтын тайланг хэлэлцэн дүгнэх.

2.4. Удирдах зөвлөл нь сангийн тухайн жилийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэн дүгнэж, ирэх оны үйл ажиллагааны төлөвлөгөөг дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор хэлэлцэж, батална.

2.5. Удирдах зөвлөлийн хурал бүх гишүүдийн гуравны хоёроос доошгүй ирцтэй хуралдаж, олонхийн саналаар шийдвэр гаргана.

2.6. Удирдах зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэсэн асуудлаар хурлын тэмдэглэл хөтөлж, түүнийг Удирдах зөвлөлийн дарга баталгаажуулна.

2.7. Удирдах зөвлөлийн дарга нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, дэд дарга нь Төвийн захирал байна. Зөвлөлийн даргын эзгүйд дэд дарга ажил үүргийг орлон гүйцэтгэнэ.

2.8. Удирдах зөвлөлийн дарга нь дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.8.1. Удирдах болон Хяналтын зөвлөлийн гишүүдийг томилуулах, өөрчлөх, гишүүдэд олгох цалин, урамшууллыг тогтоох талаар санал боловсруулж, авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлэх;

2.8.2. Авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийг боловсруулах дарааллыг тогтоох санал оруулах, сангийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх;

2.8.3. Сангийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг хэлэлцүүлж, батлуулах;

2.8.4. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зориулалт, зарцуулалтын талаар илэрсэн зөрчил, дутагдлыг цаг тухайд нь арилгуулах.

2.9. Сангийн Хяналтын зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.9.1. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

2.9.2. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих.

2.10. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.10.1. Авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичиг, үнэ бүрдэлтийг боловсронгуй болгож, шинжлэх ухааны ололт, шинэ техник, технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

2.10.2. Авто зам, замын байгууламж барих, засварлах, арчлах, зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналттай холбоотой норм, норматив, техникийн баримт бичиг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих.

2.11. Төв дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.11.1. Авто замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1.2, 11.1.4 дэх заалт болон энэ журамд заасны дагуу Удирдах зөвлөлийн баталсан төлөвлөгөө, шийдвэрийг үндэслэн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах;

2.11.2. Сангийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг гүйцэтгэх Зөвлөхийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх;

2.11.3. Авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох, олон улсын түвшинд хүргэх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж, үндсэн чиглэл, хөтөлбөр боловсруулах, гадаад орны туршлагыг судлан шаардлагатай норм, норматив техникийн баримт бичгийг худалдан авах;

2.11.4. Авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийн төсөлд мэргэжлийн түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, хараат бус хуулийн этгээд, иргэнээр шүүмж, редакц хийлгэх, санал, дүгнэлт гаргуулах;

2.11.5. Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төслийг бэлтгэж, хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2.11.6. Авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийг боловсруулах, хэвлэн олшруулах, сурталчлах, хэрэгжилтийг хангах, норм, норматив, техникийн баримт бичгийн цахим сан байгуулж, тогтмол баяжуулах ажлыг зохион байгуулах;

2.11.7. Батлагдсан төлөвлөгөөний дагуу авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийг боловсруулахад шаардлагатай ном хэвлэл, аргачлал, заавар, шаардлагатай програм болон техник хангамж, бусад тоног төхөөрөмж, техникийн баримт бичиг, материал худалдан авах, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр туршлага судлах, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;

2.11.8. Авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийн эх материал, техникийн баримт бичгийн төсөлд шүүмж, редакц хийлгэсэн санал, дүгнэлт, худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулсан холбогдох материалыг архивын нэгж болгон хадгалах

2.11.9. Авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох, шинэ дэвшилтэт техник технологийг судлах, танилцах зорилготой гадаад, дотоодын хурал зөвлөгөөн сургалт семинарт мэргэжлийн байгууллага, ажилтнуудыг хамруулах асуудлыг сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх.

Гурав. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт

3.1. Сангийн хөрөнгө нь Авто замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

3.2. Хуулийн этгээд, иргэн нь тухайн жилд гүйцэтгэх улсын болон нийслэл, орон нутаг, тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийн барилга, засвар, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын төсөвт өртгөөс 0,4 хувиар тооцож, санхүүжилтийн эрх нээгдсэнээс хойш ажлын 14 хоногт багтаан Авто замын норм, нормативын сангийн дансанд төвлөрүүлнэ

3.3. Санд хөрөнгө төвлөрүүлээгүй буюу дутуу төвлөрүүлсэн байгууллагын төлбөрийг санд нөхөн төвлөрүүлэх ажлыг Төв зохион байгуулна

Дөрөв. Сангийн хөрөнгийн зарцуулалт

4.1. Сангийн хөрөнгийг дараах арга хэмжээнд зарцуулна

4.1.1 Авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийг боловсруулах, судлах, шүүлт, үзлэг хийх, редакц, шүүмж хийлгэх, эмхэтгэн хэвлүүлэх, сурталчлах зардал;

4.1.2. Авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийг боловсруулахад шаардлагатай ном хэвлэл, аргачлал, заавар, шаардлагатай програм болон техник хангамж, бусад тоног төхөөрөмж, гадаадын норм, норматив, техникийн баримт бичиг, материал худалдан авах зардал;

4.1.3. Олон улсын мэргэжлийн байгууллагын гишүүнчлэл, хамтын ажиллагааны зардал;

4.1.4. Авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийг боловсронгуй болгохтой холбоотой хурал, зөвлөгөөн, сургалт, семинарт холбогдох ажилтнуудыг оролцуулах, тэдгээрийг зохион байгуулах, зардал;

4.1.5. Авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэхэд шаардагдах зардал;

4.1.6. Авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичиг судалгааны ажлын тайлангийн төслийг авто замын салбарын Шинжлэх ухаан техникийн зөвлөл, Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөл, Стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэх зардал;

4.1.7. Авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох, шинэ техник, технологи нэвтрүүлэхтэй холбоотой судалгаа, шинжилгээний ажил явуулах зардал;

4.1.8. Монгол Улсын Үндэсний авто замын сүлжээний бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг үүсгэх, баяжуулах, шинэчлэх, шаардлагатай програм болон техник хангамж, бусад тоног төхөөрөмж худалдан авах зардал;

4.1.9. Сангийн Удирдах болон Хяналтын зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын зардал;

4.1.10. Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах зардал.

4.2. Сангийн хөрөнгийг Авто замын тухай хууль болон энэ журамд зааснаас бусад зориулалтаар ашиглах, дараах төрлийн арга хэмжээнд зарцуулахыг хориглоно:

4.2.1. Байгууллага, хувь хүнийг ивээн тэтгэх, хандив өргөх

4.2.2. Байгууллага, аж ахуйн нэгжийн алдагдал нөхөх, баталгаа гаргах.

Тав. Сангийн үйл ажиллагааг тайлагнах


5.1. Төвийн санхүү, стандарт, норм, нормативын нэгж нь сангийн хөрөнгийн бүрдүүлэлт зарцуулалтын эхний хагас жилийн тайланг тухайн оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор жилийн эцсийн тайланг дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Удирдах зөвлөлд тайлагнана.

5.2. Сангийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төвийн вэб сайтад тус тус байршуулж, түүний хэрэгжилтийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

5.3. Хяналтын зөвлөл нь сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад жилд нэгээс доошгүй удаа хяналт, шинжилгээ хийж, тайланг Удирдах зөвлөлд танилцуулна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2018 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн
142 дугаар тушаалын хоёр дугаар хавсралт

САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН



- Дарга: Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
- Дэд дарга: "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын захирал
- Нарийн бичгийн дарга: "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын Зураг төслийн магадлал, стандарт, норм нормативын хэлтсийн дарга
- Гишүүд:
- Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
 - Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стандарт, нормативын хэлтсийн дарга
 - Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Замын ашиглалт засварын хэлтсийн дарга
 - Нийслэлийн авто замын хөгжлийн газрын дэд дарга
 - Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн
 - Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын авто замын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Авто замын салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл (зөвшилцсөнөөр)

САНГИЙН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, шинжилгээ, дотоод аудитын газрын дарга

Гишүүд:

Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, шинжилгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн

Авто замын салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл (зөвшилцсөнөөр)